

Түрэгийн түрүү үеийн Яргайтын хадны оршуулга

Ноостын Баярхүү¹, Цогтбаярын Цэлхагарав², Дунбүрээгийн Батсүх²,
Ян Бемманн³, Цагааны Төрбат^{4*}

Товч агуулга: Тус өгүүлэлд Увс аймгийн Өмнөговь сумын Яргайтын хадны оршуулгаас илэрсэн эх хэрэглэгдэхүүнийг анх удаа нийтэлж байна. Яргайтын хадны нэгэн оршуулгыг бүлэг этгээд тонож сүйтгэн 2016 онд зарим олдворуудыг зарж борлуулахыг оролдох явцад илэрч эрүүгийн хэрэг үүсэн шалгагджээ. Улмаар тус газраас олдсон олдворуудыг хураан авч ЦЕГ-аас 2017 онд тухайн үеийн ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнд шилжүүлэн хүлээлгэж өгсөн билээ. Ийнхүү уг олдворууд судлаачдын гарт ирснээр өөр бусад хадны оршуулгын олдвор болон Түрэгийн үеийн морьтой оршуулгын эх хэрэглэгдэхүүнтэй харьцуулан судлах бололцоо үүссэн юм. Үүний дээр зохиогчдын зарим нь 2019 онд уг дурсгалт газарт очин ажиллаж тонуулаас үлдсэн эд өлгийн зүйлсийг түүвэрлэн авсны дээр дурсгалын тодорхойлолтыг үйлджээ. Олдворуудын харьцангуй он цагийг Түрэгийн үед хэмээн тогтоосон бол үнэмлэхүй он цаг НТ 580-675 он буюу Түрэгийн анхдугаар хаант улсын үед холбогдох нь тодорхой болсон бөгөөд харьцуулсан судалгааны үр дүнг баталсан байна. Энэхүү дурсгал нь Их мааньт ба Жаргалант хайрханы оршуулгын хамтаар Түрэгийн үед хамаарах хадны оршуулгын харьцангуй ховор жишээ болно.

Түлхүүр үг: Хадны оршуулга, Монгол Алтай, наамал нум, Түрэгийн археологи, эсгий урлаг

Удиртгал

2016 онд тонуулчдын гарт эртний нэгэн чухал дурсгал сүйдсэн байна. Энэ бол Увс аймгийн Өмнөговь сумын нутагт орших Яргайтын хадны оршуулга болно. Тонуулчдын гараас хураасан эд өлгийн зүйлсийн түүх соёлын үнэ цэнийг Ц.Төрбат тодорхойлж, улмаар ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнд шилжүүлэн авсан нь одоо ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн сан хөмрөгт хадгалагдаж байна. Судалгааны явцад уг дурсгалаас илэрсэн нум өвөрмөц сонин хийцтэй тул эрдэм шинжилгээний хувьд тун сонирхолтой байв. Түүнчлэн энэхүү хадны оршуулгын үнэмлэхүй он цагийг Япон ба Герман улсад хийлгэсэн бөгөөд эхний удаа Сяньбийн үе гэж гарсан нь нэлээд эргэлзээ төрүүлсэн тул дахин Герман улсад илгээн радиокарбоны шинжилгээ хийлгэж Түрэгийн анхдугаар хаант улсын үед холбогдох нь тодорхой болсон билээ.

Уг дурсгал сайн хадгалалттай олдворууд ба эртний он цагаараа судалгааны ач холбогдол өндөртэй юм. 2019 онд Ц.Төрбат, Ц.Цэлхагарав нар уг дурсгалт газрыг зам зуур дахин үзэж баримтжуулах, тонуулаас үлдсэн цөөн тооны олдвор, хүний ясны хэрэглэгдэхүүнийг түүвэрлэн авах завшаан тохиолджээ. Ийнхүү Яргайтын хадны оршуулгын талаар нэлээд бүрэн ойлголтой

болж уг хэрэглэгдэхүүнийг нийтлэх боломжтой болсон юм.

Тус өгүүлэлд Яргайтын хадны оршуулгаас илэрсэн эх хэрэглэгдэхүүнийг шинжлэх ухааны үүднээс судлан шинжилж анх удаа нийтэлж байна. Үүнтэй холбоотойгоор ер нь хадны оршуулгын соёлын гарал үүслийн асуудлыг хөндөхийн сацуу Түрэгийн үеийн хадны оршуулгын судалгааны талаар авч үзсэн болно. Өөрөөр хэлбэл, бид хадны оршуулгын соёлын гарал үүслийн асуудал ба Түрэгийн үеийн хадны оршуулгын талаарх судалгааны асуудалд өөрсдийн хувь нэмрийг оруулахыг хичээв.

Судалгааны хэрэглэгдэхүүн

Энэхүү хадны оршуулга Увс аймгийн Өмнөговь сумын нутагт орших Яргайт (Харангуй Солбио) хэмээх хадан хярын оройд байжээ (Зураг 1). Хадны оршуулгыг бүлэг эдгээд 2016 онд тоносон бөгөөд олдворуудыг зарж борлуулахыг оролдох явцад хэрэг нь илэрч цагдаад баригдан эрүүгийн хэрэг үүсэн шалгагдсан түүхтэй. Уг газраас олдсон олдворуудыг 2017 онд ЦЕГ-аас тухайн үеийн Түүх, археологийн хүрээлэнд хүлээлгэн өгсөн бөгөөд одоо ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн сан хөмрөгт хадгалагдаж байна.

ЦЕГ-аас хүлээлгэж өгсөн олдворууд нь: нум, арьсан ховдонд хийсэн багц сум (багцаараа хугарсан), ховдны ясан ба төмөр бэхлэгээ, гурван талт төмөр зэвтэй мөс, хагархай модон аяга зэрэг эд өлгийн зүйлс юм.

Нумын нэг талын гичир хугарч үгүй болсон ба

¹ ХБНГУ-ын Майнц дахь Лейбницийн Археологийн төв

² ШУА-ийн Археологийн хүрээлэн, Хүрэл, төмрийн үеийн судалгааны салбар

³ ХБНГУ-ын Боннын Их Сургуулийн Өвөг ба Түүрүү түүхэн археологийн тэнхим

⁴ МУИС, Шинжлэх Ухааны Сургууль, Антропологи, Археологийн тэнхим

* Холбоо барих зохиогч: turbat.ts@num.edu.mn

<https://orcid.org/0000-0001-6606-8516>

нөгөө талын гичирний ясан наалтын үзүүр хэсэг хугарч салсан боловч нумтай нь цуг авсан байв. Хэдийгээр хугарсан боловч нумын нийт уртыг бүтэн гичиртэй талаас тооцон тогтоож болох ба дуурайлган сэргээн хийх бүрэн боломжтой юм. Учир нь гичир хугарч үгүй болсон талд элэгний наалтын доогуурх модон үүсгэр, нөгөө талын гичирний ясан наалт хугарсан хэсэгт мөн модон үүсгэр харагдаж байгаа нь нумын ерөнхий бүтцийг харах боломж олгож байна (Зураг 2).

Бод малын арьсаар хийсэн бололтой ширэн ховдонд багц сум хийсэн бөгөөд ховд ба сумны дундаас хойших хэсэг хадгалагдан үлдсэн байна. Ажиглахад анх дүүрэн сумтай ховд дагалдуулсан боловч хөрсний ус чийгний нөлөөгөөр ховд болон сумны үзүүр хэсэг норж ялзраад улмаар үгүй болсон бололтой. Одоо буй багц сум нь нийт 7 ширхэг бөгөөд бүгд оньтой, зарим нь өдтэй, мөн

онь ба өдний хэсгийг улаан, хар өнгөөр хээлэн будсан байна. Харин ховдыг бод малын зузаан ширээр хийж амсрыг гадагш нугалан эргүүлсэн ба сум авах, хийхэд зориулж нүүр талд доош дөрвөлжлөн зүсэж задгай амсартай болгож өгсөн байна. Түүнээс гадна дундуур нь хоёр бүслүүр хийж бүслүүрүүдийг ховдны ар талд савх модоор холбож өгчээ (Зураг 3.1).

Дараагийн олдвор нь ховдны амсар орчмын ясан ба төмөр бэхэлгээ. Нарийсгаж бага зэрэг нумарсан хэлбэрт оруулан зассан хавтгай яс $13 \times 1,3 \times 0,2$ см хэмжээтэй бөгөөд дээр нь хөвөөг дагуулж хүрээлээд уг хүрээн дотор уулан хээг зураасаар сийлж хоёр захад нь нэвт нүхэлж сурны үзүүр гарган зангиджээ. Харин төмөр нь шулуувтар бөгөөд нэг тал нь дугуй хэлбэртэй, дээр нь зэрэгцээ хоёр, цувраа гурван хадаасны тавтай, хэмжээ нь $15 \times 1,8 \times 0,3$ см ажээ (Зураг 3.2-3).



Зураг 1. Оршуулга илэрсэн Яргайт (Харангуй Солбио) хэмээх хадан хяр




Зураг 2. Хадны оршуулгаас илэрсэн нум

Гурван талт төмөр зэвтэй сумын мөс нэг ширхэг олдсон нь 57 см урттай. Өдтэй онь хэсэг хугарч үгүй болсон ажээ. Төмөр зэв нь $3 \times 1,5$ см хэмжээтэй ба сурвалжийг нь мөс рүү зоож нарийн шөрмөсөөр 5,5 см урт ороож бэхэлжээ (Зураг 3.4).

Сүүлийн нэг олдвор бол модон аяга юм. Аяганы нэг тал (ойролцоогоор 40% орчим) хагарч үгүй болсон боловч ёроол бүтэн бөгөөд үлдсэн хэсгээс ерөнхий хэлбэр, хэмжээг нэхэн сэргээж тооцох бүрэн боломжтой. Нэг талд нь бариулных бололтой хоёр босоо дөрвөлжин нүх (7×3 мм) мэдэгдэх ба хажуу талд нь дээд амсраас доош $2 \times 2,2$ см хэсгийг дөрвөлжлөн тайрч түүний доогуур жижиг нарийн ялтас төмрийг нэг талд нь хадсан хэвээр бэхлэгдэн үлдсэн байна. Уг ялтас төмрийн зэв болсон мөрийг харахад аягыг хэрэглэж

байх явцад дээрээс доош зэрэгцээ байдлаар 3-4 цуурсныг уг төмрөөр хөндлөн чигт хадаж (цууралтыг тогтоох зорилгоор) бэхэлж байжээ (Зураг 4).

Улмаар 2019 онд судлаачид уг хадны оршуулгын байрлалыг тогтоож, орчны ба хөмөг доторх байдлын гэрэл зургийг авч, уг газарт үлдэж хоцорсон цөөн олдвор ба хүний ясны үлдэгдэлийг түүвэрлэн авчээ (Зураг 5). Хөмөгний дотор талд хүний хурууны яс, арьс ширний тасархай, сумны мөсний хугархай болон өнгө алаглуулан (цагаан, бор) ширж хийсэн нарийн хийцтэй эсгий эдлэлийн үлдэгдэл тонуулчдын дараа үлдэж хоцорсон байна. Мөн уг хөмөгт амьтан үүрлэж багагүй эвдрэл гэмтэл учруулсан нь илэрхий ажиглагдаж байжээ (Төрбат нар 2019).



Зураг 3. Хадны оршуулгын зарим олдвор. 1 – Ширэн ховдтой багц сум; 2 – Ховдны ясан бэхэлгээ; 3 – Ховдны төмөр бэхэлгээ; 4 – Төмөр зэвтэй хугархай сум



Зураг 4. Хадны оршуулгаас илэрсэн модон аяга

Түүвэрлэн авсан олдворын тодорхойлолт:

1. Эсгий эдлэлийн хэсэг: 70×46 см хэмжээтэй. 1,7 см зузаан. Бор болон цагаан өнгийн ноосоор өнгө алаглуулан 6 үе давхарлан маш нягт нямбай ширж хийжээ.

2. Даавууны хэсэг: 6×4,5 см хэмжээтэй. Цэцгэн хээтэй даавууны хэсэг.

3. Сурны тасархай: 0,5 см өргөнтэй нарийхан сурны хэсэг.

4. Сумны мөсний хугархайнууд: Олон хэсэг болж хугарчээ.

5. Хүний хөлийн тавхайн яснууд: Хурууны яс 4 ш, тавхайн яс 2 ш.

6. Сураар ороосон модны хэсэг. 175 см урттай, 12 см өргөнтэй. Нарийн сураар ороосон байдалтай байна.

Хэлэлцүүлэг

Төв Азийн хадны оршуулгын соёл НТ IV-VI зууны үеэс эхэлсэн гэж үздэг байна (Кызласов 1986; Түвшинжаргал, Баярсайхан 2017). Харин Түрэгийн хоёрдугаар хаант улсын үеэс хадны оршуулга олон болж хойшлох тутам энэ зан үйл ихэд дэлгэрсэн байдаг (Törbat *et al.* 2009; Кубарев 2005; Соенов *и др.* 2002; Төрбат нар 2009; Хүрэлсүх, Мөнхбаяр 2004).

Чухам юуны учир агуй, хадны хөмөг, хөндий ашиглаж оршуулга үйлдэх болсон талаар тодорхой баримт мэдээ үгүй боловч энэ нь бүр эрт цагт буюу хүн төрөлхтөн оромжтой болоогүй байх тэр үед уулын агуй, хонгил, газар сууц зэрэгт овог аймгаараа амьдарч

байсан бөгөөд хожим нас барагсадаа ил задгай газарт орхих бус “орон гэрт нь үлдээх” гэсэн утга агуулга, сэдлээс үүссэн байхыг үгүйсгэх аргагүй. Жишээлбэл, Дорнод аймгийн Халхгол сумын Тамсагбулагийн сууцны шалан доороос олдсон оршуулга бол неолитийн төгсгөл, энеолитийн эхэн үед холбогдох одоогоор Монгол нутгаас илрээд буй хамгийн эртний оршуулга юм. Энэ оршуулга хэдийгээр уулын агуй, хонгилд үйлдсэн “хадны оршуулга” биш боловч “газар сууц”-ны дотор, шалан доороос нь илэрснээрээ агуй, хонгил, хадны хөмөгт оршуулж байгаатай утга агуулгын хувьд дүйж байгаа төдийгүй мөн тэнд амьдарч байсан хүнийг нас эцэслэхэд тухайн гэрт нь үлдээсэн байхыг үгүйсгэх аргагүй тул бидний дээрх таамаглалтай шууд нийцэж байна.

Ингэж үзвэл, “хадны оршуулга”-ын гарал үүсэл нь эртний хүмүүс нас барагсадаа өвөг дээдсийнхээ амьдарч байсан гэр, оромжинд тавих нь тэдэнтэйгээ нөгөө ертөнцөд үүрд хамт байна гэсэн санаанаас үүсэлтэй байж болох талтай. Хэдийгээр баталгаа, нотолгоотой биш боловч энэ зан үйлийн шууд улбаа байж болох нэгэн хэлц монголчуудын дунд өнөөг хүртэл хэлэгддэг нь “ханан гэрээс холдож хадан гэрт ойртлоо” гэдэг билээ. Энэ хэлцийн талаар манай ахмад археологчидын хийсэн судалгаа бий бөгөөд хүмүүсийн оюун сэтгэлгээн дэх “газар эх” гэх ойлголттой салшгүй холбоотойгоор энэхүү хэлц үүссэн гэж тайлбарласан байдаг (Мэнэс, Билэгт 1992).

Энэ үгийг өндөр настай, өвчин зовлонтой өтөл насны хүмүүс хэлдэг ба орчин цагийн “шилжсэн утга”-аар бол “одоо миний насны тоо гүйцэж байна, удахгүй халих цаг минь ирлээ” гэдгээ хэлж буй



Зураг 5. Хадны оршуулгаас 2019 онд түүвэрлэн авсан олдворууд

утга боловч цаад далд утга буюу эртний мартагдсан агуулга нь одоо энэ гэрээсээ явж уулын агуй, хадны хонгил, хөмөгт очих цаг минь ойртлоо гэсэн санааг “шууд” илэрхийлж байгаа хэллэг юм. Тиймээс эртний нүүдэлчдийн ертөнцийг үзэх үзэлтэй холбоотойгоор “хадны оршуулга” хэмээх оршуулгын нэгэн хэлбэр ийнхүү үүссэн байх боломжтой.

Сүүлийн үеийн нэгэн судалгаагаар Монгол улсын нутагт нийт 70 гаруй газар 100 орчим хадны оршуулгын дурсгалыг малтан судалжээ. Эдгээрийн он цагийг тодорхойлсон байдлаас үзэхэд хамгийн эртнийх нь IV зууны сүүл үед, хожуу үеийнх нь XVII зууны эхэн үед холбогдох бөгөөд энэ нь хадны оршуулга Монгол нутагт эрт дээр үед үүсч, түүнтэй уялдсан оршуулгын зан үйл бүрэлдэн тогтсоныг гэрчилнэ (Эрдэнэбат 2020).

Түрэгийн үеийн хадны оршуулгууд

Одоогоор Түрэгийн үед холбогдох хадны оршуулга маш цөөн илэрсэн нь нэг талаараа энэ чиглэлийн дагнасан судалгаа хийгдээгүй байгаатай холбоотой боловч нөгөө талаар мэргэжлийн археологичд олж илрүүлэн судлахаас өмнө малчин ард иргэд барагшуун хайх нэрийн дор уул хадаар хэсүүчлэн хадны оршуулгуудыг олж олдвор хэрэглэгдэхүүнийг нь эртний эдлэл сонирхогчдод зарж ашиг хонжоо олох зорилгоор сүйтгэх, толгой дараалан тонох явдал эрс ихэссэнтэй шууд холбоотой юм. Хэдий тийм боловч одоогоор мэргэжлийн судлаачид тодорхой судалгаа хийж он цагийг баттай тогтоосон, Түрэгийн үед холбогдох хадны оршуулга ердөө хоёр байгаа нь Баян-Өлгий аймгийн Буянт сумын Их Мааньтын хадны оршуулга ба Ховд аймгийн Манхан сумын Жаргалант хайрханы хадны оршуулга юм.

Их мааньтын хадны оршуулгыг 1989, 1990 онуудад Баян-Өлгий аймгийн нутагт археологийн карт зохиох ажлын хүрээнд хийсэн хайгуулын судалгааны явцад Буянт сумын нутаг, Хөх сайны нурууны Их мааньт хэмээх газраас олж илрүүлжээ (Баяр, Эрдэнэбаатар 1989; Эрдэнэбаатар 1996). Анхны мэдээллийг нутгийн малчин иргэн өгсөн бөгөөд газар дээр нь очиж шалгахад зэрлэг амьтдын хөлөөр зөөгдөж ил гарсан оршуулга байсан бөгөөд тухайн үед антропологийн хэмжилт судалгаанд хүний гавлын яс, он цаг тогтоох судалгаанд оршуулганд хэрэглэсэн гэрийн хананы үлдэгдэлээс дээж авсан ба дагалдах ямар нэг эд өлгийн зүйл илрээгүй ажээ. Анхны байрлал алдагдаж бүрэн хөндөгдсөн төдийгүй харьцуулан судлах ямар нэг эд өлгийн зүйл илрээгүй боловч оршуулганд хэрэглэсэн гэрийн хананы үлдэгдэлд хийсэн C14-ийн он цаг тогтоох шинжилгээгээр энэ булш нь VIII зууны дунд үед холбогдохыг тогтоосон байдаг (Эрдэнэбаатар 1996).

Харин Жаргалант хайрханы хадны оршуулгыг 2008 онд “Монгол Алтайн баруун хэсгийн түүх, археологийн дурсгалууд-II” төслийн хүрээнд тус сумын нутагт түүх, археологийн дурсгалын хайгуул, бүртгэл судалгааны ажил хийх явцад олж илрүүлэн малтан судалсан байна. Уг дурсгалын талаар хэд хэдэн өгүүлэл нийтлэгдсэн төдийгүй эрдэм шинжилгээний бүтээл гарсан тул энд нуршсангүй (Батсүх, Батбаяр 2014; Төрбат нар 2008).

Үүнээс гадна Түрэгийн үед холбогдож болох хадны оршуулгын олдворууд бий боловч он цагийн нарийвчилсан судлагаа хийгдээгүй, эсвэл бүр хийх боломжгүй тохиолдол хэд хэд байна. Нарийвчилсан судалгаа хийж чадаагүй байгаа учир нь тонуулчдын гарт өртөж сүйдсэн хойно зарим нэг олдвор нь цагдаагийн газар, хувь хүний гараас дамжуулан олж авсан байх тул хийц загварын хувьд төстэй боловч баттай он цаг тогтоогоогүй олдворууд, он цаг тогтоох дээж авах боломжгүй зэрэг шалтгаанууд бий. Жишээлбэл, он цаг тогтоох дээж авах боломжгүй нэгэн жишээг дурдвал: 2016 онд Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын нутагт орон нутгийн зарим иргэд барагшуун хайх нэрийдлээр уул хадаар явж байгаад эртний эд зүйлс олж аваад явсан гэх малчдын өгсөн мэдээллийн дагуу уг газарт очиж шалгаж үзэхэд хэд хэдэн хадны оршуулгыг тонож сүйтгэсэн байжээ. Төлөөлөл болгон нэгийг дурдвал, Хагтын Хөх жалга хэмээх газарт, том том үхэр чулууны тогтоцтой уулын дунд хэрд нэгэн том боржин чулууны хөндийд байсан хадны оршуулгыг сүйтгэсэн байв. Хадны хөмгийг бүрэн сэндийчиж хүний ясыг гадагш гаргаж хаяснаас ганц нэг хавирга, мөчний ясны хугархай хөрсөн дээр ил хэвтэхээс гадна эвдэрч сүйдсэн модон эдлэлийн үлдэгдлүүд, хугархай модон сам зэргийг олж илрүүлсэн юм. Гэтэл эдгээр нь анхны байрлал алдагдсанаас гадна хэдэн сарын өмнө хадны хөмгөөс ил гаргаж хаясан тул хур борооны усанд норх зэргээр бохирдсон тул он цаг тогтоох шинжилгээ хийх нь төдийлөн баталгаатай бус юм.

Тэгвэл он цаг тогтоогоогүй олдворуудын жишээг дурдвал: мөн Баян-Өлгий аймгийн Сагсай сумын нутаг, Бөхөн уулаас олдсон гэх нэг нум, арьсан саадагтай хэд хэдэн сумны мөсний хугархайтай олдворууд бий. Эдгээр олдворыг нутгийн малчин иргэн барагшуун хайж явахдаа олсон гэх бөгөөд аймгийн төвд авч ирж тодорхой мөнгөн дүнгээр худалдсан байдаг (Золбаяр, Жаргалсайхан 2012). Уг нум ба сумны зэвүүдийн хийц зэргийг харьцуулан үзэхэд Түрэгийн үед холбогдох боломжтой ба одоогоор лабораторийн нарийн он цаг тогтоох шинжилгээ хараахан хийгдээгүй байна. Энэ мэт шинжилгээ судалгаа хийх боломжтой болон боломжгүй тохиолдлууд олон бий.


Яргайтын хадны оршуулгын зарим олдворуудын онцлог ба он цаг

Яргайтын хадны оршуулгаас гарсан эд өлгийн зүйлсийг бусад хадны оршуулгыг Түрэгийн морьтой оршуулгын хэрэглэгдэхүүнтэй харьцуулан үзэхэд Түрэгийн үед холбогдохыг батлах хэд хэдэн шинж бий. Тухайлбал, зан үйлийн шинж тэмдэг ба олдвор эд өлгийн зүйлсийн адил төстэй шинж тэмдгүүдийг дурдаж болно.

Зан үйлийн шинж тэмдэг нь энэ үеийн морьтой оршуулга ба хадны оршуулганд идээ ундааны сав, хувцас хэрэглэл, зэр зэвсгийн зүйлс дагалдуулах нь түгээмэл. Яргайтын хадны оршуулгаас хэдийгээр бүрэн бүтэн хадгалагдаагүй боловч хувцасны үлдэгдэл даавуу, эсгийний тасархай зэргээс гадна нумыг багц сумтай буюу зэр зэвсэгтэй нь дагалдуулсан байжээ. Мөн бүтэн хадгалагдаж үлдээгүй боловч модон аяга буюу оршуулгын идээний савыг дагалдуулсан байна. Морьтой оршуулгаас одоогоор модон аяга гарсан тохиолдол хараахан үгүй бөгөөд энэ нь хөрсөнд хадгалагдаж үлддэггүйтэй холбоотой. Гэхдээ мод биш боловч шавар ваар бүтэн ба хагарсан байдалтай илэрдэг. Харин Түрэгийн язгууртны болон жирийн тахилгын онгоны малтлагаар үүнтэй төстэй хэлбэртэй сав илэрсэн тохиолдлууд бий. Жишээлбэл, Түрэгийн Билгэ хааны тахилгын онгоны малтлагаас гарсан олон тооны үнэт олдвор дотор үүнтэй төстэй хэлбэртэй, жижгэрүүлсэн хувилбар буюу миниатюр алт, мөнгөн савнууд бий. Мөн Төв аймгийн Заамар сумын Шороон бумбагараас олдсон ёроолдоо руни бичигтэй мөнгөн сав (Осова нар 2011) хэмжээний хувьд ойролцоо ажээ. Ийм алт, мөнгө, зэсээр хийсэн сав Монгол болон хөрс зэргэлдээ бүс нутгаас олноор илэрч олддог.

Тэгвэл өөр харьцуулан судалж болох олдворууд гэвэл зүймэл нум, сум ба төмөр зэв зэргийг дурдаж болно. Түрэгийн үед холбогдохыг баттай тогтоосон хадны оршуулгаас илэрсэн зүймэл нум гэвэл юуны түрүүнд Жаргалант хайрханы хадны оршуулгын нум болно. Энэ хоёр нум хэдийгээр зүймэл нумын ангилалд багтах боловч хийцийн хувьд эрс ялгаатай. Жаргалант хайрханы нумын модон үүсгэр нь нэг модоор үргэлж хийж, эвэр элэг, ясан гичир, мөн бариул хэсгийг яс, эврээр зүүж хийсэн бол Яргайтын нумын модон үүсгэр нь үргэлж биш, тус тусд нь буюу гичир, элэг, бариул хэсгийг бүгдийг зүүж хийсэн бололтой байна. Ялангуяа эвэр элэгийн хэсэг Яргайтын нумынх илүү өргөн бөгөөд хавтгай бол Жаргалант хайрханы нум нарийн бөгөөд зузаан, мөн 30 см гаруй урт гичиртэй. Харин Яргайтын нумын нэг талын гичрийн үзүүр ясан бэхэлгээ хугарсан боловч эвээрээ нийлэх бөгөөд 20 см гаруй ажээ. Энэ нь нумын хийц буюу дээр дурдсан нумын элэгтэй шууд холбоотой юм. Өөрөөр хэлбэл өргөн хавтгай элэгтэй бол урт гичир хэрэггүй тул богино гичиртэй байхад харин эсэргээрээ нарийн бөгөөд зузаан элэгтэй нум урт гичиртэй байдаг бололтой. Тиймээс хоёр хадны оршуулгын нум хийцийн хувьд харилцан адилгүй боловч зан үйлийн хувьд зэр зэвсгийг нь дагалдуулж тавьсанаар ижилсэж байна гэж үзэж болно.

Яргайтын хадны оршуулгаас нэг хугархай сум (төмөр зэвтэй), бас нэг багц сумын хугарай мөсүүд (7 ш) бүгд арьсан хоромсого дотор багцаараа бий бөгөөд зарим дээр нь улаан, хар будгаар будаж чимэглэсэн байх ба онь хэсгийг шөрмөсөөр ороож мөн зарим нь өдтэйгээ байна. Сум нь дөрвөн талдаа өдтэй байгаа нь Жаргалант хайрханы сумуудтай ижилсэж байна. Дээр дурдсан нэг ширхэг хугархай сумны төмөр зэв



Зураг 6. Яргайтын оршуулгаас илэрсэн ясанд хийсэн C14 үнэмлэхүй он цагийн мэдээ

нь гурван талт зэв бөгөөд Жаргалант хайрханы хадны оршуулгаас ийм төрлийн зэв нэлээд олон тоогоор илэрсэн байна (Батсүх, Батбаяр 2014).

Ийнхүү биет олдворуудыг харьцуулан үзэхэд харьцангуй он цаг үндсэнээ Түрэгийн үед холбогдохыг зааж байгаа бол C14-ийн он цаг ч үүнийг давхар баталж байна. Уг хадны оршуулгаас гарсан модноос авсан дээжид Германы Кёльний их сургуулийн AMS лабораторид хийсэн шинжилгээний үр дүнд НТ 580-675 он буюу Түрэгийн анхдугаар хаант улсын үед холбогдох нь тодорхой болсон билээ (Зураг 6).

Дүгнэлт

Увс аймгийн Өмнөговь сумын Яргайтаас 2017 онд тоногдож эд өлгийн зарим зүйлсийг зарахыг завдах явцдаа баригдаж улмаар цагдаагийн газраас хурааж авсан олдворуудыг мэргэжлийн байгууллагад хүлээлгэж өгснөөр энэхүү хадны оршуулгыг судлах боломж нээгдсэн юм. Улмаар 2019 онд зохиогчдын зарим нь зам зуурт зорин очиж хадны оршуулга байсан агуйг үзэж шалгах, гэрэл зургаар баримжуулах боломж бүрдсэнээр тус хадны оршуулгыг нэхэн судлах боломжтой болсон билээ.

Хадны оршуулгаас зарим ясны үлдэгдэл, эд өлгийн зүйлс илэрсэн боловч нас, хүйсийг тодорхойлох гол яснууд үгүй болсон тул дагалдуулсан зарим эд зүйлст тулгуурлан үзвэл эрэгтэй хүний оршуулга байх магадлалтай. Учир нь хадны оршуулгууд болон морьтой оршуулгын малтлагуудаас харахад эмэгтэйчүүдийн оршуулгаас илүүтэй эрэгтэй хүний оршуулганд зэр зэвсгийн зүйлс дагалдуулах нь түгээмэл байдаг. Үүнтэй холбож үзэхэд Яргайтын хадны оршуулга нь эрэгтэй хүний оршуулга байсан гэж үзэж байна.

Ийнхүү хэдийгээр тоногдож сүйдсэн боловч олдвор хэрэглэгдэхүүн нь судлаачдын гарт эргэн олдож, нэхэн судлах бололцоо олсон нь олзуурхууштай төдийгүй дундад эртний түүхэнд, ялангуяа булш, оршуулгын зан үйлийн судалгаанд ач холбогдолтой нэгэн чухал хэрэглэгдэхүүн болохыг дурдах нь зүйтэй. Тухайлбал, Яргайтын оршуулгаас гарсан наамал нумыг цаашид дэлгэрүүлэн судлах шаардлагатай бөгөөд Монголын эртний нумын бүтэц хийцийг Хүннүгийн нумтай холбож өгсөн завсрын шинжтэй чухал олдвор болохыг онцлон тэмдэглэе.

Талархал

Эртний түүхийн ховор олдворыг шуналын сэдлээр ашиг хонжоо хайн зарж борлуулах гэж байсан бусармаг үйлдлийг таслан зогсоож, мэргэжлийн судлаачдад нэхэн судлах боломжийг олгож шилжүүлэн өгсөн ЦЕГ-ын ажилтнуудад болон Увс аймгийн Өмнөговь

суманд ажиллах үед туслалцаа үзүүлсэн Т.Цэгмид багш, Соёлын төвийн эрхлэгч Б.Батболд, Цагдаагийн хэсгийн дарга, дэд хурандаа Д.Буянжаргал нарт гүн талархал илэрхийлье.

Abstract

Yargait rock burial of the Early Turkic period

Noost Bayarkhuu, Tsogtbayar Tselkhagarav,
Dunburee Batsukh, Jan Bemmann & Tsagaan Turbat

In this article, the original finds from the Yargait rock tomb in the Ömnögovii sum, Uvs Aimag, are published for the first time. In 2016, a group of people looted the site and tried to sell some of the artifacts. As a result, the artifacts were confiscated and handed over to the then Institute of History and Archaeology by the Central Bureau of Police in 2017. The authors carried out a comparative analysis to compare the findings with other rock grave assemblages and with the grave goods of ancient Türkic horse-accompanied burials.

In addition, some of the authors carried out fieldwork at the site in 2019, providing a detailed description of the site and discovering further artifacts despite the previous looting. The study of the comparative finds allows a dating to the Early Türkic period, which was confirmed by the radiocarbon dating of a wood sample to 580-675 CE, roughly corresponding to the era of the first Türk Khaganate. Together with the monuments of Ikh Maanit and Jargalant Khaikhan, it is one of the few rock burials from the Türk period.

Keywords: Rock burials, Mongolian Altai, composite bow, archaeology of Türk Khaganate, felt making

Ном зүй

Törbat, T., Batsukh, D., Bemmann, J., Höllmann, T., Zieme, P. (2009). A Rock Tomb of the Ancient Turkic Period in the Zhargalant Khaikhan Mountains, Khovd Aimag, with the Oldest Preserved Horse-head Fiddle in Mongolia. – a Preliminary Report. In Current Archaeological Research in Mongolia. Papers from the First International Conference on “Archaeological Research in Mongolia” held in Ulaanbaatar, August 19th-23rd, 2007. 365–383.

Батсүх, Д., Батбаяр, Т. (2014). Жаргалант хайрханы хадны оршуулга. Талын морьтон дайчдын өв соёл: VII-XIV зууны Монголын хадны оршуулгын шилмэл хэрэглэгдэхүүн. Эрдэм шинжилгээний каталог. Ред. Ц.Төрбат, У.Эрдэнэбат. 2014: 207–242.

Баттулга, Ц. (2014). Жаргалант хайрханы хөгжмийн зэмсэг дээрх эртний бичээс. Ред. Төрбат,

Ц, Эрдэнэбат, У. Талын морьтон дайчдын өв соёл (VII-XIV зууны Монголын хадны оршуулгын шилмэл хэрэглэгдэхүүн). Эрдэм шинжилгээний каталоги. 2014: 171–179.

Баяр, Д., Эрдэнэбаатар, Д. (1989). 1989 онд Баян-Өлгий аймгийн нутагт явуулсан эртний судлалын хайгуулын ажлын тайлан. ШУА-ийн Түүхийн хүрээлэн.

Золбаяр, Г., Жаргалсайхан, Б. (2012). Шинээр олдсон нэгэн нум сумны тухайд. Эрдэм шинжилгээний илтгэл. ШУА-ийн Харъяа Баян-Өлгий аймаг дахь Нийгэм эдийн засгийн судалгааны Төв. 2012: 145–147.

Кубарев, Г. В. (2005). Культура древних тюрок Алтая (по материалам погребальных памятников).

Кызласов, И. Л. (1986). Новый вид погребальных памятников Южной Сибири. Материалы по археологии Горного Алтая. 1986: 100–129.

Мэнэс, Г., Билэгт, Л. (1992). Об одном скальном погребении XII-XVI вв. из бассейна реки Керулен. Пятый Международный Конгресс Монголоведов. Том. III. 1992: 155–159.

Окладников, А. П., Худяков, Ю. С. (1981). Образ война на писанницах Монголии. Военное дело древних племен Сибири и Центральной Азии. 1981: 21–29.

Осова, Т., Сүзүки, К., Лхүндэв, Г. (2011). Заамарын Шороон довоос олдсон мөнгөн саван дээрх руни бичээс. *Studia Archaeologica*, XXX(8), 140–144.

Серегин, Н. Н. (2018). Скальные погребения Алтая и сопредельных территорий раннего средневековья: культурно-хронологическая и этносоциальная интерпретация. *ПА*, 2(24), 41–51. <https://doi.org/10.24852/pa2018.2.24.41.51>

Соенов, В. И., Трифанова, С. В., Вдовина, Т. А., Яжанкина, С. И. (2002). Средневековое скальное захоронение в Каменном Логу. *Древности Алтая*, 9, 117–124.

Төрбат, Ц., Батсүх, Д., Батбаяр, Т., Баярхүү, Н., Идэрхангай, Т. (2008). Монгол Алтайгаас илрүүлсэн хадны оршуулгууд. *Studia Archaeologica*, XXV(14), 266–284.

Төрбат, Ц., Өмирбек, Б., Цэлхагарав, Ц. (2019). Хээрийн шинжилгээний ангийн тэмдэглэл. УБ.

Түвшинжаргал, Т., Баярсайхан, Ж. (2017). Урд Улаан Үнээт уулын хадны оршуулга: Эмээлийн түүхэн хөгжлийн асуудалд. *Nomadic Heritage Studies*, 18–2(7), 79–93.

Хүрэлсүх, С., Мөнхбаяр, Л. (2004). Рашаантын Ам ба Цанхирын агуйн оршуулгууд. *Acta Historica*, V, 20–30.

Эрдэнэбаатар, Д. (1996). Монгол Алтайн хадны оршуулга. *Studia Archaeologica*, XVI(9), 113–121.

Эрдэнэбат, У. (2020). Монгол булш, түүний хэв шинж, онцлог. Ред. А. Очир, Ц. Төрбат. Монголчуудын уг гарал: Археологийн судалгаа. УБ.

Эрдэнэбат, У., Амартүвшин, Ч. (2010). Дугуй Цахирын хадны оршуулга (X-XII зуун). УБ.

Received: Feb 7, 2024; Revised: Feb 26, 2024; Accepted: March 13, 2024

